



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№210 /419/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.11.21

Цаг үе, үйл явдал

АГААРЫН ЦЭРГИЙНХЭН МЭРГЭЖЛЭЭРЭЭ ӨРСӨЛДЛӨӨ



ЗХЖШ-аас 2023 оныг "Залуу офицер, ахлагч нарыг дэмжих жил" болгосонтой холбогдуулан Агаарын цэргийн командлалаас "Агаарын цэргийн мэргэжлийн аварга офицер, ахлагч" шалгаруулах тэмцээнийг хоёр үе шаттайгаар амжилттай зохион байгуулж энэ сарын 18-ны өдөр мэргэжлийн аваргуудаа тодрууллаа.

Тэмцээнд Агаарын цэргийн харьяа

5 ангийн 100 гаруй офицер, ахлагч нисэх, зенитийн пуужин, радиотехникийн мэргэжлээр өрсөлдсөнөөс радиотехникийн мэргэжлийн аварга офицерын төрөлд дэслэгч Б.Шинэзаяа (325) тэргүүн байр, дэслэгч Б.Баянсан (065) дэд байр, радиотехникийн мэргэжлийн аварга ахлагчийн төрөлд ахлагч С.Мөнх-Эрдэнэ (065) тэргүүн байр, ахлагч Б.Хүрэлбаатар (065) дэд байр, зенит пуужингийн мэргэжлийн аварга

офицерын төрөлд ахлах дэслэгч Д.Эрдэнэжаргал (353) тэргүүн байр, дэслэгч С.Намсрай (353) дэд байр, зенит пуужингийн мэргэжлийн аварга ахлагчийн төрөлд ахлагч Б.Мөнх-эрдэнэ (353) тэргүүн байр, дэд ахлагч А.Мөнх-Эрдэнэ (353) дэд байр, нисэхийн мэргэжлийн аварга офицерын төрөлд ахлах дэслэгч Н.Оюунболд (337) тэргүүн байр, ахлах дэслэгч Б.Түмэн-Өлзий (337) дэд байр, нисэхийн мэргэжлийн аварга ахлагчийн төрөлд ахлагч Ү.Эрдэнэбаяр (303) тэргүүн байр, ахлагч Э.Мөнхбат (337) дэд байрт тус тус шалгарч мэргэжлийн аваргын тэмдэг, өргөмжлөл, мэргэжлийн зэргийн эзэд боллоо.

Энэхүү тэмцээн нь Агаарын цэргийн үндсэн мэргэжлийн офицер, ахлагч нарын мэргэжлийн болон тактикийн мэдлэг, ур чадвар, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор Агаарын цэргийн командлалаас 2 жилд нэг удаа уламжлал болгон явуулдаг ч энэ жилийн тэмцээнд зөвхөн залуу офицер, ахлагч нар буюу сургууль төгсөөд 5 жил хүртэл ажиллаж байгаа бүрэлдэхүүний дунд явуулсан нь онцлог байлаа.

Тус тэмцээний хаалтын үйл ажиллагаанд Агаарын цэргийн командлалын Агаарын довтолгооноос хамгаалах хэлтсийн дарга хурандаа Ч.Буянзаяа оролцож, тэмцээнд амжилт үзүүлж байр эзэлсэн бүрэлдэхүүнд шагналыг нь гардуулан өгч нийт бие бүрэлдэхүүнд ажил, мэргэжлийн амжилтыг хүслээ.

АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 0	☁️ -11


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 21

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.432	3.437
EUR 🇪🇺	3.555	3.565
CNY 🇨🇳	476	479
RUB 🇷🇺	53.90	54.20
JPY 🇯🇵	24.50	24.70
KRW 🇰🇷	2.57	2.60

ЗУРХАЙ



2022.11.21 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 28

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЦЭРГИЙН ГАЛ ТОГОО БАРИГДАНА



Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын хөрөнгө оруулалт, дэмжлэг болон зарим орон нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Хуурай замын цэргийн хэд хэдэн нэгтгэл, ангид бүтээн байгуулалтын ажлууд өрнөж байна.

Үүний үргэлжлэл болж Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн цэргийн гал тогооны шав тавих ёслол болов. Өмнөговь аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалтаар баригдах энэхүү цэргийн гал тогоог 2023 оны 9 дүгээр сар гэхэд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. Барилгыг Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн барилгачин дайчид гүйцэтгэнэ.

Мөн энэ жил алба хаагчдынхаа ажиллах орчин нөхцөлийг дээшлүүлэх бодлогын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн цэргийн гал тогоог Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн барилгачин дайчид бүрэн хэмжээнд шинэчлэн засварлаж, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн цэргийн гал тогоог Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн бүтээн байгуулагчид төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байна.

Түүнчлэн Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд БХЯ, ЗХЖШ-аас "Цэргийн жишиг хотхон" төслийг анхлан хэрэгжүүлж эхлээд байна. **ЗХЖШ**

НАМАЙГ АЛГАС



Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Орхон аймгийн Цагдаагийн газартай хамтран "Намайг алгас" аяны хүрээнд ангийн нийт бие бүрэлдэхүүнд "Архи, согтууруулах ундааны хор хөнөөл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх нь" сэдвээр энэ сарын 18-ны өдөр Цагдаагийн газрын ахлах мэргэжилтэн цагдаагийн ахмад Г.Эрдэнэбаяр сургалт зохион байгуулж явууллаа.

Ахмад Т.МӨНХ-ЭРДЭНЭ

БУУДЛАГА АМЖИЛТТАЙ



Зэвсэгт хүчний 338 дугаар анги

Цэргийн жинхэнэ албанд 2022 оны хоёрдугаар ээлжээр татагдан ирсэн дайчид цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад амжилттай хамрагдаж автоматын анхны дасгалыг нийт 3 удаа боловсруулснаас 2022 оны 11 дүгээр сарын 18-нд тангаргийн баярын буудлагаа явуулж 13 "Онц буудагч" тодорлоо. **Дэслэгч Б.ПҮРЭВЛХАМ**

НАМРЫН АДАГ ЦАГААН НОХОЙ САР ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ШАР БАР ӨДӨР

Үс засуулбал:

Хэрүүл тэмцэл ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.07-17.09

Барилдлага:

Үл зохилдох

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Хурьцахуй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 643,136,385

Эдгэрсэн

Нийт: 622,372,670

Нас барсан

Нийт: 6,626,124

Цаг үе, үйл явдал

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗЭО ДУГААР АНГИД...



БУУДЛАГА АМЖИЛТАЙ

“Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу” ангийн нийт бие бүрэлдэхүүн буудлагын дасгал боловсрууллаа.

Сургалтын явцад Дархан-Уул аймгийн Цагдаагийн байгууллагаас нийт бие бүрэлдэхүүнд “Зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах”, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Гэр бүл хоорондын харилцаа, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь”, “Мөрийтэй тоглоом”, “Цахим гэмт хэргийн хор уршиг” зэрэг сэдвээр сургалтыг зохион байгуулав.

Тус анги нь ЗХЖШ-ын дарга, ТХЦК-ын өгсөн албан даалгаврын хүрээнд мэргэжлийн байгууллагатай хамтарсан сургалт, дадлагыг тогтмол явуулж байна.



ЦУГЛАРАХ ДОХИОГООР АЖИЛЛАВ

2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангах бие, бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх, үүрэг гүйцэтгэх түвшинг нэмэгдүүлэх зорилгоор алба хаагчдыг “цугларах” дохиогоор ажиллууллаа.

Мөн энэ үеэр анги цугларах районд гарч, үүрэг гүйцэтгэх томилгоот бүлгүүдийг тодотгон бэлэн байдлыг шалгаж, штабын хэсэгчилсэн дадлагыг хээрийн байрлалд явуулан орчин үеийн нөхцөл байдалд нийцсэн хэлбэрээр захирамж өгч дадлага сургуулийг зохион байгуулсан нь бие бүрэлдэхүүний мэдлэг, ур чадварыг сорьсон, хөгжүүлсэн дадлага сургалт боллоо.



СПАРТАКИАД ТАВАН ТӨРЛӨӨР...

Бие бүрэлдэхүүний спортын бэлтгэлжилтийн түвшнийг шалгах, хамт олны нэгдмэл уур амьсгалыг дээшлүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах зорилгоор спортын өдөрлөгийг зохион байгууллаа.

Тэмцээн 100м гүйлт, 200м буухиа, 400 метрийн зайнд рот салбараар туулах хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд энэ үеэр Зэвсэгт хүчний болон Улс, аймгийн уралдаан тэмцээнд амжилттай оролцсон тамирчин цэргийн алба хаагч нараа алдаршуулж хүндэтгэл үзүүлэв.

Дараагийн өдөр бие бүрэлдэхүүн Дархан хотын “Өргөө кино театр”-т тэтгэвэр чөлөөндөө гарсан ахмад дайчдын хамт ЗУРА-2 /Цурам ажиллагаа/ киног үзэж сонирхсон нь бүрэлдэхүүний дунд халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлсэн явдал болсон юм.

Ахмад Б.ХАНДСҮРЭН

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗЭО ДУГААР АНГИД...



30 КИЛОМЕТРИЙН ЯВГАН МАРШ ҮЙЛДЭВ

2022-2023 оны сургуулийн жилийн сургалт, бэлтгэлийн

төлөвлөгөөний дагуу тус ангийн бие бүрэлдэхүүн 30 км-ийн явган марш үйлдлээ.

Маршийн явцад хордсон газар орныг туулах, инженерийн саадын гарцаар гарах, отолтоос гарах, тактикийн ажиллагааг гүйцэтгэх, хууль бус шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрэх зэрэг ажиллагааг бодит цагийн байдалтай нийцүүлэн явуулав. Мөн энэ үеэр түр амралтыг Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө баатарлаг гавьяа байгуулсан Ц.Хасбаатарын хөшөө цогцолборын районд зохион байгуулж, түүний гүйцэтгэсэн үүрэг, алдар гавьяаг алба хаагчдад танилцуулсан юм.



БАРИЛГАЧИН ДАЙЧИД АНХНЫ БУУДЛАГАА ХИЙЛЭЭ

Энэ оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан ирсэн шинэ дайчид цэргийн анхан шатны бэлтгэлдээ амжилттай хамрагдаж байна.

Тэд 2022-2023 оны сургуулийн жилийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу энэ

сарын 18-ны өдөр буудлагын анхны дасгалаа боловсруулсан юм.

Бие бүрэлдэхүүнийг хөдөлгөөн үйлдэхийн өмнө ангийн захирагчийн тушаал, буудлагын үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулсны зэрэгцээ буудлагын болон хөдөлгөөний үед нэн тэргүүнд аюулгүй байдлыг ханган ажиллахыг үүрэг болгосон юм. Буудлагын үеэр 11 байлдагч онц дүнтэй буудаж үеийн нөхдөө манлайллаа.

Тус буудлага нь хугацаат цэргийн алба хаагчид онолын мэдлэгээ дадлагаар баталгаажуулан цаашид буудлагын зэвсгийг чадварлаг эзэмших, мэргэн буудах арга барилын суурийг тавьсан үр дүнтэй дадлага болсон юм.

Д.УЯНГАА

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАЛААР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл нь Цагдаагийн Ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газартай хамтран “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай” сэдвээр энэ сарын 18-ны өдөр сургалт зохион байгууллаа.

Сургалтад Батлан хамгаалахын удирдлагын академи, Цэргийн нэгдсэн дээд сургууль, Аюулгүй байдлын дээд сургууль, Цэргийн хөгжмийн политехникийн коллеж,

Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн багш, сонсогч, оюутнууд болон Харуул үйлчилгээний ротын хугацаат цэргийн алба хаагчид оролцлоо.

Тус сургалт нь бие бүрэлдэхүүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын сөрөг үр дагаврыг таниулж, хэрэглээг таслан зогсоох, нөлөөллийн аргаар эрсдэлээс сэргийлэх талаар тодорхой ойлголтыг өгсөн үр дүнтэй сургалт болж өндөрлөсөн юм.

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №25

МА ГИЙГҮҮЛЭГЧИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ

МА бол дэвсгэр үсэг, түүний дотор зөөлөн дэвсгэр юм. Үгийн дунд, төгсгөлд ардаа эгшиггүй орж болно гэсэн үг.

МА үсгийн үндсэн бүтэц бол НА-гийн адил титэм бөгөөд ялгах зурлага “гээг” нэмж бичдэг. Үгийн дунд, адагт дэвсгэрлэвэл “шүд, гээг”-ээр тэмдэглэнэ. Эхлээд нурууны шугам дээр титэм, дунд бол шүд зурлагаа бичиж дуусаад, үзгээ салган гээгийг титэм, шүдэнд нь зайгүй нийлүүлж бичдэг. Та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд орох МА, МЭ, МИ, МО, МУ, МӨ, МҮ гэж аялгуулан уншиж, хувирах хэлбэрийг тогтоогтун.

Бичмэл тигээр:

